

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 оны жилийн эцэс

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|--|--|---|------------------|---|--------------------------------------|--|-------------------|
| 1. Нэг: “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд: | | | | | | | |
| 1 | 1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлнэ | 1.1.1. Сумын нутаг дэвсгэрт коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, салбар дундын зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангана. | 2021 - 2024 | | | Сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн А/07 захирамжаар Шуурхай штабыг шинэчлэн байгуулсан. Сумын хэмжээнд коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, цаг агаар, өвөлжилт, хаваржилтийн нөхцөл байдал дээр урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөн шуурхай штабын гишүүд болон ард иргэдэд цаг тухай бүр нь мэдээ, мэдээлэл хүргэн үүрэг чиглэл өгч ажилладаг. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдах эм эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцасын нөөцийг 3 сараар хангаж бэлтгэсэн. 10 ортой тусгаарлах байрыг Эрүүл мэндийн сайдын 505, 536, 537, 538, 539 дүгээр тушаалын дагуу бэлдэж хүний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Ковид-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын байрны сургалтыг улиралд 2 удаа хийж мэдлэг мэргэжлээ дээшлүүлж ажилласан. Сургалтын өмнөх мэдлэг 77%, сургалтын дараах сорил 93%-иар өссөн. Хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх, тайлах дарааллыг ажлын байрны сургалтаар 8 удаа хийж өмсөж хэвшсэн. | 100% |
| 2 | | 1.1.2. Хорио цээр, хязгаарлалтын | 2021 - | | | Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед Эрүүл мэндийн төв нь шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, | 100% |

| | | | | | | | |
|---|--|---|-------------|--|--|--|------|
| | | дэглэм тогтоосон үед эрүүл мэндийн салбарын хэмжээний шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй, хомсдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, нөөцийг бүрдүүлнэ. | 2024 | | | хувийн хамгаалах хэрэгсэл, оношлуур халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй, хомсдол үүсэхээс сэргийлж 3 сарын нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. | |
| 3 | | 1.1.3. Цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, иргэдэд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн | 2021 - 2024 | | | Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааг ард иргэдэд цахим болон видео шторк, контент хэлбэрээр түгээн дэлгэрүүлэн хүргэж ажилласан. "Маскаа зүүж хэвшье", "Гараа тогтмол угаая" зэрэг сэдвүүдээр Төрийн албан хаагч 57, Ерөний боловсролын сургуулийн 37 багш ажилчид, 467 сурагчдад сургалт хийж гарын авлага брошур тараасан. Сургууль, дотуур байр, Цэцэрлэгийн гал тогоо, ОО-ын өрөөнүүдэд тус бүр гар угаах дарааллыг байршуулж багш, тогооч нарт зөвлөгөө өгч ажилласан. Сургууль, Цэцэрлэгийн гал тогооноос гарч байгаа энгийн хог хаягдлын талаар зөвлөгөө өгч ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|--|--|-------------|--|--|---|------|
| | | мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмжийг хүргэх, сэрэмжлүүлэг мэдээлэлээр хангах ажлыг эрчимжүүлэн зохион байгуулна. | | | | | |
| 4 | | 1.1.4. “Ковид-19” вирусийн халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг салбар дундын оролцоотой хийж, үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | Энэ 2023 онд Коронавирус өвчлөл бүртгэгдээгүй. | 0% |
| 5 | | 1.1.5. Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, | 2021 - 2024 | | | Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах бэлэн байдлын 10 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан ажилласан. Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдах эм эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцасны нөөцийг 3 сараар хангаж бэлтгэсэн. 10 ортой тусгаарлах байрыг Эрүүл мэндийн сайдын 505, 536, 537, 538, 539 дүгээр тушаалын дагуу бэлдэж хүний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Ковид-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын байрны | 100% |

| | | | | | | |
|--|--------------------------------------|---|-------------|--|--|------|
| | | тусгаарлах болон эмчлэн тусгаарлах байруудын бэлэн байдлыг шуурхай хангаж эмч эмнэлгийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх арга барилд сургах ажлын байрны тасралтгүй сургалтыг тогтмол зохион байгуулж ур чадварыг нь дээшлүүлэн аюул эрсдлээс урьдчилан сэргийлж эрүүл мэндээр хохироохгүй байх арга хэмжээг авч ажиллана | | | сургалтыг улиралд 2 удаа хийж мэдлэг мэргэжлээ дээшлүүлж ажилласан. Сургалтын өмнөх мэдлэг 77%, сургалтын дараах сорил 93%-иар өссөн. Хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх, тайлах дарааллыг ажлын байрны сургалтаар 8 удаа хийж өмсөж хэвшсэн. Халдвар хамгааллын дэглэмийг өндөр түвшинд барьж ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндийн сургалт сурталчилгааг ард иргэдэд цахим болон видео шторк, контент хэлбэрээр түгээн дэлгэрүүлэн хүргэж ажилласан. "Маскаа зүүж хэвшье", "Гараа тогтмол угаая" зэрэг сэдвүүдээр Төрийн албан хаагч 57, Ерөний боловсролын сургуулийн 37 багш ажилчид, 467 сурагчдад сургалт хийж гарын авлага брошур тараасан. Сургууль, дотуур байр, Цэцэрлэгийн гал тогоо, ОО-ын өрөөнүүдэд тус бүр гар угаах дарааллыг байршуулж багш, тогооч нарт зөвлөгөө өгч ажилласан. Сургууль, Цэцэрлэгийн гал тогооноос гарч байгаа энгийн хог хаягдлын талаар зөвлөгөө өгч ажилласан. Эмнэлэг, Сургууль, Цэцэрлэгийн тогооч нарыг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамруулж ажилласан. Цахилгааны эх үүсвэрийн нөөцийг, түргэн тусламжийн авто машины бэлэн байдлыг ханган ажиллаж байна. | |
| 2. ХОЁР. Хүний хөгжлийн бодлогын хүрээнд | | | | | | |
| 6 | 2.1. Эрүүл иргэн -Ирээдүйн үнэт зүйл | 2.1.1. Төсөвт албан байгууллагуудыг ажлын байран дээрээ артерийн даралт, биеийн жингээ хэмжих, эрүүл мэндээ хамгаалахад | 2021 - 2024 | | Эрүүл мэндийн төв нь ажлын байран дээрээ эрүүл мэндээ хамгаалахад зориулан 2022 онд шинээр биеийн жин, өндөр, индекс хэмжигч, артерийн даралт хэмжигчүүдийг кордорт байрлуулсан. Ингэснээр албан хаагчид болон үйлчлүүлэгчид биеийн жин, өндөр, индекс, артерийн даралтаа өөрөө үзэх боломж бүрдсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|--|--|-------------|--|--|--|------|
| | | зориулсан тоног төхөөрөмжийг бий болгон ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ. | | | | | |
| 7 | | 2.1.2. Эм эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг ханган, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ. | 2021 - 2024 | | | Эм эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор “Эмийн санд тавих нийтлэг шаардлага” MNS 5260:2015 стандарт 10.3 дах хэсгийг мөрдөн ажиллаж байна. Засгийн газрын 2003 оны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 196 дугаар тогтоолын 4-р хавсралтын 2.2 дах заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон хэрэгцээтэй эм болон амин чухал эм эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад заасан анхан шатлалын эмнэлэгт шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг 3 сарын нөөцөөр хангасан мөн эм хэрэгслийн тасалдалын бүртгэлийг хөтөлж байна. Тусгаарлах өрөөг шаардлага хангасан эм эмнэлгийн хэрэгслээр хангаж хэвийн ажиллуулж байна. Эмийн жорын маягт жор бичилт MNS 5376:2016 стандартын 6 дахь хэсгийн дагуу тус суманд ажиллаж байгаа 2 эмийн санд дотоодын хяналт хийж хяналтаар илэрсэн дутагдлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дархлаажуулалтын кабинетэд яаралтай тусламжийн эмүүдийг журамд заасан нэр төрлөөр нь бүрдүүлж бэлэн байдлыг ханган ажилласан. Лабораторийн урвалж, оношлуур болон хэрэгсэл хүлээж авах, хадгалах баримтжуулсан журам гарган мөрдөн ажиллуулж байна. | 100% |
| 8 | | 2.1.3. Иргэдийн зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс | 2021 - 2024 | | | 2023 оны 04 дүгээр сарын 12 ны өдөр тус эрүүл мэндийн төвийн эмч ажилчид 3 баг болон сумын төвийн лагер, хороолол, төрийн болон хувийн хэвшлийн 9 газраар явж ариутгал хийж, 21 дадлын талаарх мэдлэгийг үнэлэн 135 айл өрхөд “Заавал хэвшүүлэх 21 дадал” -ын сургалтын | 90% |

| | | | | | |
|---|--|-------------|--|--|-----|
| | урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг зохион байгуулах замаар өвчлөлийг бууруулж, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлнэ. | | | материал тараав. 2023 оны 04 дугаар сарын 19 ноос 04 дугаар сарын 22 – ний өдрүүдэд “Эрүүл мэндийн довтолгоо” 3 хоногийн арга хэмжээг зохион байгуулж ажиллаа. Үйл ажиллагааны хуваарын дагуу эрүүл мэндийн төвийн эмч ажилчид дараах багуудад хуваагдан сумын төвд түр болон байнга оршин суудаг 140 өрх айлын нэрсэг гаргаж, чиглэл чиглэлээр хуваан авч “ Айл өрхүүдээс эрүүл зан үйл хэвшүүлэх судалгаа авсан байдал” гэсэн судалгааны хуудасыг бөглөж үнэлгээ хийв. Судалгаагаар: Халдварт өвчний сэргийлэлтийн талаар, Хамар залгиур нь хэвийн эсэхийг үзлэг хийх, Хоолой зайлах уусмалаар хоолойгоо зайлж хэвшсэн эсэхийг тодруулж, Тухайн айл бактерийн эсрэг саван ашигладаг эсэхийг, Стандарт бохирын цооногтой эсэх, Хог түр хадгалах савтай эсэх, Гэр бүлийн гишүүдийн шүдний сойз тусдаа эсэх, Гар нүүрний алчуур тусдаа эсэх, Ус нөөцлөх савыг 7 хоногт хэдэн удаа угаадаг тоо, Гэр бүлийн гишүүд тусдаа өмчилсөн аяга халбагатай эсэх айл бүр угаалгын булантай эсэх гэсэн 10 асуудтаар үнэлхэд тухайн айлын ариун цэвэрийн балл 5 буюу цэвэрч айл 57 байна. Бусад айл өрхүүд ариун цэвэрч байдал ямар нэг хэмжээгээр дутагдалтай байв. Зөв зохистой хооллолтын талаар 6 асуумжаар тухайн өрхийн хоолны хэрэглээг үнэлэн газар дээр нь зөвөлгөө өгч “Заавал хэвшүүлэх 21 дадал” – ын танилцуулга бүхий 130 дэвтэр тараан, сургалт хийв. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндээ өөрсдөө сахин хамгаалах, осол гэмтлээс хэрхэн сэргийлэх талаар асуумж авахад 450 өрхийн 1185 хүнд зөвлөгөө өгч ажиллаа. Эрт илрүүлэгийн үзлэг шинжилгээнд багийн эмч нар урилга тараан хамруулан ажиллаж байна. | |
| 9 | 2.1.4. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр эрэлт хэрэгцээнд нийцсэн, хувийн | 2021 - 2024 | | Уламжлалтын эмч сувилагчийн орон тооны дутагдалтай. | 30% |

| | | | | | | | |
|----|--|---|-------------|--|--|---|------|
| | | хэвшлийн эмнэлгийг хөгжүүлнэ. | | | | | |
| 10 | | 2.1.5. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, резидент сургалтад хамруулах, ур чадварын нэмэгдэл олгох, салбарын удирдлагын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | Их эмчийн сургалтын зардалыг Сумын Засаг даргын нөөц хөрөнгө болон орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлнэ. | | Эрүүл мэндийн төв нь 2023 онд 1 сувилагч ахлах зэрэгийн шалгалтад орж тэнцсэн. 2024 онд ЭХО-ны сургалтад 1 их эмчийг мэргэжил дээшлүүлхээр төлөвлөж байна. | 90% |
| 11 | | 2.1.6. Эмийн сангийн менежментийг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн хэлбэрээр хөгжүүлж эм эмнэлгийн хэрэгслийн чанартай ханган нийлүүлэлт үнийн уян хатан бодлого | 2021 - 2024 | | | Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвд "Мандал гоо фарм", "Залаа-Аминдэм" эмийн сангууд ажиллаж байна. Мандалгоо фарм эмийн сантай 2022-2023 онд Эрүүл мэндийн газрын дарга, Эрүүл мэндийн төвийн дарга нартай гурвалсан гэрээ байгуулсан. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг 3 сараар бэлдэж ханган нийлүүлж ажиллаж байна. Эмийн үнийн уян хатан бодлогийг хэрэгжүүлэн орчин үеийн нотолгоонд суурилсан оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд хэрэглэгдэх эм эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангаж байна. Эрүүл мэндийн даатгалаар олгогдох хөнгөлттэй эмийн жорын эрхийг Мандалгоо фарм эмийн сан нь 11 сард авч сумын ард иргэдэд үйлчилж байна. Эрүүл мэндийн | 100% |

| | | | | | | |
|----|--|---|-------------|---------|---|------|
| | | хэрэгжүүлнэ. | | | даатгалаар олгогдох эмийн хомсдол үүсээгүй. Тус эмийн сан нь Новартис үйлдвэрийн жагсаалтад орсон эмүүдийг ард иргэдэд ЭМД-р үнэгүй олгон ажиллаж байна. Эмийн сангийн өрөөний стандартыг бүрдүүлж ажилласан. Залаа-Аминдэм эмийн сан нь ЭМД-р олгогдох хөнгөлттэй эмийн жорын эрхээ аваагүй байна. Эмийн зохистой хэрэглээний талаар ард иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилладаг. | |
| 12 | | 2.1.7. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ | 2021 - 2024 | 5000000 | <p>2023 оны 01 дүгээр сарын 10-нд эхлэж 3 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 3 сарын хугацаатай сумдаа байгууллага дээрээ өглөө 11 цагт ажлын байрны дасгалыг хийж байгууллага болгон брэнд бүжигтэй болсон. Өглөөний дасгалдаа идэвхтэй оролцож жин хассан албан хаагчийг жилийн эцэсээр шагнаж урамшуулна. Эрүүл мэндийн төвтэйгээ хамтран ажилласан. Сумдаа өглөөний дасгалаа 07-08:30 цагийн хооронд 3 сарын турш өрнүүлж, 06 дугаар сарын 14 өдөр аянаа дүгнэн, хаалтын үйл ажиллагаагаа хийж, Цаг гаргая аян албан байгууллага, гэр бүл, ахмад, сум, гэсэн 4 чиглэлээр Баянхонгор аймагт шалгарна. Цаг гаргая аяныхаа мэдээлэлийг 6 дугаар сарын 10-ны дотор мэдээ тайлангаа Баянхонгор аймгийн Биеийн тамир спортын газарт цаасаар тайлангаа явуулж дүгнүүлсэн.</p> <p>“Эрүүл иргэн - Эртэч Шинэжинстчүүд” Цаг гаргая аянд 10 хүүхэд 45 ахмад, албан байгууллагууд хамрагдаж, гэр бүл-4 албан байгууллага-5 нийт давхардсан тоогоор 675 хүн өглөөний дасгал, нарны алхалтанд хамрагдсан байна. Шинэжинст сумаас хамгийн тасралтгүй идэвхтэй хамрагдсан Ахмад настангууд, 3 Гэр бүлүүд идэвхтэй хамрагдлаа. Энэхүү аяныхаа хүрээнд Баянхонгор аймагтаа Шинэжинст сум 3-р байрт шалгарсан. Баянхонгор аймгийн говийн бүсийн сумдын сургуулийн ажилчдын урлаг спортын наадам: Тус сумд зохион байгуулагдаж 6 сум ирж спортын 3-н төрөлт тэмцээнийг ЕБС-ийн багш нартай хамтран зохион байгуулсан. Эмэгтэйчүүдийн зөвлөлөөс волейболын тэмцээн зохион байгуулсан бөгөөд тус тэмцээнд 11 багийн нийт 70 гаруй тамирчид оролцов. Эх үрсийн баярт</p> | 100% |

| | | | | | | |
|----|--|---|-------------|--|--|------|
| | | | | | зориулсан Волейболын тэмцээн зохион байгуулагдсан. Монголын үндэсний спортын VII наадмын Баянхонгор аймгийн анхан шатны тэмцээний Үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах барилдаанд Д.Бат-Эрдэнэ 3-р байр эзэлсэн. | |
| 13 | 2.2. Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас хэрэгжүүлж буй хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилтийг хангах | 2.2.1. Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэдийн зөв зохистой хооллолтыг дэмжих сургалт сурталчилгааг тогтмол хийж хүн амын дундах хоол хүнсний далд чихэр тослогийг бууруулан эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллийг багасгах замаар илүүдэл жингээс сэргийлэх, бөөр зүрх судасны өвчлөлийг бууруулан үр дүнг тооцно. | 2021 - 2024 | | Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөрийн хүрээнд сахарын хэрэглээг бууруулах зорилгоор сар бүрийн 15-ны өдрүүдийг чихэргүй өдөр болгон өнгөрүүлдэг. Иргэдийн дундах давсны хэрэглээг бууруулах зорилгоор эмнэлгийн ажилчид болон ард иргэдийн дунд “Давсаа хасъя” сэдвээр сургалт хийж гарын авлага тараасан. Сургалтад нийт 263 хүн хамрагдсан. Арга хэмжээнд оролцсон иргэдийн бүртгэл хийж, өндөр жин үзэж сургалтын үеэр Мандалгоо эмийн сан амны маск, витамин тараасан. Мөн өртөөчилсөн хоолны амталгаа явагдаж эрүүл мэндийн төвийн эмч нар тухайн хоолны талаар зөвлөгөөг иргэдэд өгөв. 1-р өртөө артерийн даралт, 2-р өртөө таргалалт, 3-р өртөө бөөр, 4-р өртөө элэг цес нойр булчирхай, 5-р өртөө ходоод, 6-р өртөө зүрх судас, гэсэн өртөөчилсэн байдлаар өөрийн өвчинд нь тохирсон хоолны амталгаагаар иргэдэд үйлчилсэн. 2023 онд даралт ихдэлтээр 3, иргэн илүүдэл жинтэй 6, бөөрний үрэвсэл 11, илэрсэнийг эмчлэн эрүүлжүүлж диспансерийн хяналтад авсан. Хавсралт нийт : 11 Файл : 1 Зураг : 10 | 100% |
| 14 | | 2.2.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг | 2021 - 2024 | | Шинэжинст сумын Эрүүл мэндийн төвийн Чанар аюулгүй байдлыг сайжруулах 2023-2024 оны төлөвлөгөөг Эрүүл мэндийн хөгжлийн төвд илгээж батлуулсан. Чанарын баг нь 5 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг Энэ онд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан эрүүл мэндийн | 100% |

| | | | | | | |
|----|----------------------------------|--|-------------|--|---|-----|
| | | нэмэгдүүлэн иргэдийн хүлээгдэл чирэгдлийг бууруулна. | | | тусламж үйлчилгээний сургалтад цахимаар 2 удаа хамрагдсан. Аймгийн ЭМГ-с тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хариу арга хэмжээ авах сургалтад 1 их эмч, 1 бага эмч танхимаар хамрагдсан байна. 2022-2026 онуудын байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой эрүүл мэндийн статистик үзүүлэлт, хүний нөөц, санхүү, багаж тоног төхөөрөмжийн талаар сүүлийн 5 жилийн мэдээний санг бий болгосон. 2023 онд сайн мэдээ-11, алдаа зөрчил бүртгэгдээгүй, алдах дөхсөн тохиолдол -1. ЭМС-ын А/566 тоот тушаалын 4 дүгээр хавсралтаар ижил мэргэжилтний үнэлгээг 2 удаа хийсэн. Сумын Эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 онд 24 орон тоо батлагдсанаас 22 буюу 91.6%-тай ажиллаж байна. Эмч эмнэлэгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, харилцаа хандлагын тухай ажлын байрны сургалтыг улиралд 1 удаа зохион байгуулсан. Эрүүл мэндийн газар болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан цахим сургалтад 2 удаа хамрагдсан. Ёс зүйн алдаа зөрчил бүртгэгдээгүй. Нотолгоонд тулгуурласан чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх зорилтын дор цусны ерөнхий шинжилгээ, шээсний ерөнхий шинжилгээ болон В, С-Гепатит, ДОХ, БЗДХ, Сахар, холестрин, цагаан хорхой, хелекобактери зэрэг шинжилгээнүүдийг авч оношилгоо шинжилгээнд хэрэглэж байна. Иргэдэд тусламж үйлчилгээг чанартай хүргэхийн тулд шээсний шинжилгээний аппаратыг шинээр 2023 онд авсан бусад дагалдах урвалж бодисуудын тасалдал үүсгэхгүй хэвийн ажиллаж байна. Лабораторийн үйл ажиллагаанд гадаад, дотоод хяналтыг тухай бүр хийж хэвшсэн. Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар эерэг сэтгэгдэл 88.6%-тай байсан ба бичгээр ирсэн өргөдөл гомдол байгаагүй. Угтах үйлчилгээг нэвтрүүлж үйлчлэгч нар үүдэнд жижүүрлэн хөтөч хийх ширээг ажиллуулж байна. | |
| 15 | 2.3. Хүн бүрт чанартай боловсрол | 2.3.1. Багш, сурагчдын сурч хөгжих, хүүхдэд | 2021 - 2024 | | Багш бүр таблет ашиглаж сурах, хичээл сургалтадаа ашиглах чиглэлээр зочинтой хичээл, хичээл судалгаа арга хэмжээг 2 удаа зохион байгуулж нийт 23 багш оролцсон. | 90% |

| | | | | | | | |
|----|--|--|-------------|--|--|--|------|
| | эзэмшүүлж, боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ. | ээлтэй сургалтын орчин бүрдүүлж, багшийн мэргэжлийн болон багшлах ур чадварыг нэмэгдүүлнэ. | | | | Багш нарын ээлжит хичээлийн чанарыг сайжруулах заах ур чадварыг дээшлүүлэх, шилдэг арга зүй туршлагаа түгээн дэлгэрүүлэх зорилготой “Зочинтой хичээл”, “Нээлтэй хичээл” арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Залуу багш нарыг чадавхжуулах ур чадварын уралдааныг хавар 1, намар 2 удаа зохион байгуулж нийт 22 баг 4 багт хуваагдан оролцож давхардсан тоогоор 15 багшид 15 хувийн цалингийн нэмэгдэл олгосон байна. | |
| 16 | | 2.3.2. Сургууль, эцэг эх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжсэн хөрөнгө оруулалт хийсэн иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжинэ. | 2021 - 2024 | | | ерөнхий боловсролын сургуул 23 багш 20 үйлчилгээний ажилтан 2 удирадах ажилтан нийт 45 хүний нөөцийн бүрэлдэхүүнтэйгээр боловсролын үйлчилгээг 420 сурагчид үзүүлж байна. хичээлийн шинэ жил эхэлэх үед эцэг эх, асран хамгаалагч, сурагч, багш гэсэн гурвласан гэрээг нийт 420 сурагч, эцэг эх, асран хамгаалагчтай байгуулж ажиллаж байна. 2023-2024 оны хичээлийн жилийн 2 дугаар улирлын байдлаар сургуулиас зохион байгуулагдсан уралдаан тэмцээнийг 4 эцэг эх 780000 төгрөг, дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах гуравдугаар багийн эцэг эхчүүд 45000 төгрөгний ус буцалгагч, дотуур байрны сурагчдад төмөр аягыг нийт эцэг эхийн 720000 төгрөгний хандиваар тус тус авсан байна. нийтдээ 50 гаруй эцэг, эх асран хамгаалагчаас 1545000 төгрөгний хандив, тусламж авсан байна. | 100% |
| 17 | | 2.3.3. Сургууль, цэцэрлэг, соёлын төвийг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилгын засвараар үе шаттай хангаж, удирдлагын чадавхийг | 2021 - 2024 | | | Ерөнхий боловсролын дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмж, ширээ сандлын шинэчлэл, өргөтгөлийн төслийг бичиж СЭКЕР РЕСОПСУС компанид хүргүүлснээр дэмжигдэж 44.152.000 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 9.405.000 төгрөгийн ширээ сандал нийт 53.557.000 төгрөгийн өртөг бүхий хөрөнгө оруулалт хийгдлээ. Мөн хичээлийн байр, дотуур байр, гадна талбайд орчин үеийн шаардлага хангасан 23.397.550 төгрөгийн өртөг бүхий камерыг суурилууллаа. | 100% |

| | | | | | | | |
|----|--|---|-------------|--------|--|---|------|
| | | сайжруулна. | | | | | |
| 18 | | 2.3.4. Боловсролын байгууллагуудын хамран сургалтыг 100 хувьд хүргэнэ. | 2021 - 2024 | | | 2023-2024 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид 65 сурагч элссэн бөгөөд 06 настны хамрагдалт 90 хувьтай байна. Мөн өдрийн ангид 5 тусгай хэрэгцээт хүүхэд сууж байна. Үүнээс 3 хүүхэд анги удирдсан багш нар тусгай ганцаарчилсан хөтөлбөрөөр хичээл ордог бөгөөд тус багш нарт хуульд заасны дагуу 10 хувийн нэмэгдлийг олгож байна. | 90% |
| 19 | | 2.3.5. “Сайн багш” хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | 2020 онд хэрэгжээд дуусан тул жагсаалтаас хасас | 100% |
| 20 | | 2.3.6. “Хүүхдийн амьдрах ухааны төв, хөдөлмөр зуслан” –д сурагчдыг хамруулна. | 2021 - 2024 | | | хийгдээгүй | 0% |
| 21 | | 2.3.7. Сургуулийн өмнөх боловсрол, сургуульд “Авьяас” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | 2016 онд хэрэгжээд дууссан хасах | 100% |
| 22 | | 2.3.8. Орон нутагт дутагдалтай байгаа захиалгат мэргэжлээр “Суралцаж байгаа оюутнуудыг боловсролын зээлийн сан”-д | 2021 - 2024 | 60 сая | | Сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Эрдэнэ монгол” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд “Амралтаараа ажиллая” оюутан хөтөлбөр хэрэгжүүлж, 19 оюутан ЗДТГ-ын албан хаагчдад дагалдах ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ мод арчлах, услах ажлыг хийлцэж ажилласан нь ногоон байгууламжийг нэмэгдүүэхэд тус дэм болсон ажлын нэг байлаа. | 70% |

| | | | | | | |
|----|--|-------------|--|--|--|------|
| | болон тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна. | | | | | |
| 23 | 2.3.9. “Монгол ухаан” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | | ТУС хөтөлбөрийн хүрээнд Монгол наадгай болох шагайн өв соёлыг түгээн дэлгэрүүлэх үүднээс эцэг эхийн оролцоотойгоор дотуур байрны тасаг бүрт нэг нэг буюу нийт 12 ширхэг "Шагай наадгайн багц"-ыг бий болголоо. Тус багцад богцтой шагай, шагайн олбог, шагай шүүрэлтийн хөө хуяг, их бага шарга, алаг мэлхийн өрлөг зэрэг орсон болно. | 70% |
| 24 | 2.3.10. Сурагчдын оюуныг хөгжүүлэх, бие даан суралцах, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, уралдаан, тэмцээн, олимпиад зохион байгуулах. Санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. | 2021 - 2024 | | | 2023 онд Баянцаган суманд зохион байгуулагдсан говийн бүсийн аварга шалгаруулах тэмцээн гутгаар байр нийт 23 сурагч, U14 насны Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд эрэгтэй эмэгтэй нийт 18 сурагч, Баянхонгор аймагт зохион байгуулагдсан Монголын хүүхдийн их наадмын сорилго тэмцээнд Handball ийн төрөлд гутгаар байр нийт 9 сурагч, . Шударга уншигч аймгийн Монгол бичгийн уралдаанд 9а ангийн сурагч Ж Энхмэнд дөрөвдүгээр байр, Монголын оюутны холбооны дэргэдэх Лидер академ холбооноос зохион байгуулсан Аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнд гутгаар байр нийт 11 сурагч, Найзууд Алтан цомын багийн халз барилдаанд 5 дугаар байр нийт 7 сурагч, аймгийн 7 дугаар ангийн сурагчдын Монгол бичгийн олимпиадад Х.Сэржмядаг багштай 7Б анги хамт олон буюу 18 сурагч "Хөрвүүлэх" төрөлд дэд байр зэрэг тус тус амжилттай оролцсон. мөн сургуулийн оны аварга шалгаруулах намрын спартакиадын тэмцээнд нийт 144 сурагч оролцсон байна. | 90% |
| 25 | 2.3.11. “Хос бичигтэн”, “Англи хэл”, “Робокон-Баянхонгор”, дэд хөтөлбөрүүдийг | 2021 - 2024 | | | Робокон-Баянхонгор, Англи хэл хөтөлбөр хэрэгжээд дууссан. хасах саналтай байна. Хос Үндэсний хөтөлбөр-3 хүрээнд төрийн албан хаагчдын дунд “Нэрийн хуудас”-аа үндэсний бичгээр бичих уралдаан зарлаж нийт 5 байгууллагын 85 төрийн албан хаагч нэрийн хуудастай | 100% |

| | | | | | | |
|----|--|---|-------------|--|--|------|
| | | хэрэгжүүлэх. | | | болсон. Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчдад 14 хоногийн сургалтыг нэг удаа зохион байгуулж нийт 42 хүн хамрагдлаа. Төрийн албан хаагчдын дунд 2 үе шаттай үндэсний бичгийн олимпиадыг монгол хэлний багш нартай хамтран зохион байгууллаа. Нийт 13 албан хаагч оролцлоо. Сурагчдын амралтын хугацаанд давхардсан тоогоор 45 багш ажилчдад компьютерт үндэсний бичгээр бичих программ суулгаж дадлага сургуулилалтыг хийлээ. Ажилчдын баярыг угтсан “Хос сайхан бичигтэн” шалгаруулах уралдаан зарлан эхний 3 байрыг шалгаруулж шагналаа. Өргөмжлөл , дурсамжаа тогтмол үндэсний бичгээрээ бичиж хэвшсэн. Сургуулийн 42 албан хаагчид “Хүмүүн бичиг” сонин 100% захиалан захиалга өгсөн. 6-8-р ангийн сурагчдын монгол хэл, бичгийн чадварыг дээшлүүлэх зорилгоор “Бид чадна” үндэсний бичгийн өртөөчилсэн тэмцээнийг дараах төрлүүдээр явууллаа. 6-р ангийн сурагчид үндэсний бичгээр бичсэн үгсийг 1 минутад унших 7-р анги кириллээр бичсэн хэлц үгсийн утгыг 1 минутад тайлбарлах 8-р анги галигаар өгөгдсөн өвөрмөц бичлэгтэй үгсийг орчин цагийн дуудлагаар унших зэрэг өртөөнүүдийг дамжин оролцож, 1-р байр Х.Сэржмядаг багштай 6б анги 2-р байр М.Байгальмаа багштай 7а анги 3-р байр Ж.Пагма багштай 6А анги эхний 3 байрт шалгарлаа. Бийрийн бичгийн сургалтад нийт 7 сурагч хамрагдаж амжилттай суралцсан. 6-9 дүгээр ангийн сурагчдын үндэсний бичгийн стандарт хангалтын үнэлгээгээр амжилт 38, чанар 14, гүйцэтгэл 46 хувьтай гарсан. мөн аймгийн хэмжээний 7 дугаар ангиудын дунд зохион байгуулсан Монгол бичгийн олимпиадад Хөрвүүлэх төрөлд Х.Сэржмядаг багштай 7Б анги хамт олон дэд байранд орлоо. | |
| 26 | | 2.3.12. Боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, | 2021 - 2024 | | Төрөлжсөн олимпиадын 2 ын даваанд багш суралцагчдаа оролцуулсан. Математикийн олимпиадын 6,8-р ангийн төрөлд сурагч Л.Түвшинзаяа, Ю.Амармандах нар 4-р байр, Олон улсын Кенгеру олимпиадад нийт 47 цахимаар | 100% |

| | | | | | | |
|----|--|--|-------------|--|---|-----|
| | | суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч багшийг бий болгож, чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлж шагнаж урамшуулна. | | | оролцож 18 сурагч 1-3 дугаар зэргийн дипломын болзол хангажээ. Мөн ажиллаж байгаа үндсэн багшаас англи хэлний багш Н.Нармандах бакалавр, магистрт эчнээгээр суралцаж байна. Үндсэн сургалтад 1 дэх жилдээ ажиллаж байгаа 3, 5 дахь жилдээ ажиллаж байгаа 1 багш сууж батламжаа авсан байна. Аймгийн Боловсрол, Шинжлэх ухааны газраас зохион байгуулсан “Бага боловсролын хүрээнд хэрэгжүүлж байгаа ЭГРА, ЭГМА шилдэг туршлага хэлэлцүүлэх” зөвлөгөөнд бага боловсролын багш Э.Дүүрэнхундага, “Бүтээлч багачууд Шилдэг арга зүй” уралдаанд бага боловсролын багш М.Нансалмаа, “Бага ангийн багш нарын дунд зохион байгуулагдсан ур чадвар 2023 -Нээлттэй хичээлийн уралдаан”-д бага боловсролын багш Д.Отгонцэцэг, Д.Ганболор нар тус тус амжилттай оролцсон. Багш нарын ээлжит хичээлийн чанарыг сайжруулах заах ур чадварыг дээшлүүлэх, шилдэг арга зүй туршлагаа түгээн дэлгэрүүлэх зорилготой “Зочинтой хичээл”, “Нээлтэй хичээл” арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Залуу багш нарыг чадавхжуулах ур чадварын уралдааныг хавар 1, намар 2 удаа зохион байгуулж нийт 22 баг 4 багт хуваагдан оролцож давхардсан тоогоор 15 багшид 15 хувийн цалингийн нэмэгдэл олгосон байна. Aplus.mn сургалтад 22 багш мэргэжлийн болон сонголтод сургалтыг , нийгмийн ажилтан , сургалтын менежер, захирал нар чадваржуулах нэг сургалтыг сонголоо. | |
| 27 | | 2.3.13. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, цахим, сургалтыг хөгжүүлж, иргэдийн тасралтгүй | 2021 - 2024 | | Цахим ур чадварын 30 цагийн төлөвлөгөө гаргаж ажиллаж байна. Цахим дээр анхан шатны сургалтад 5 иргэнд 2 цаг, E-mongolia сургалтад 4 цаг, Gmail дээр хаяг нээх яаж ашиглах талаар сургалтад 4 цаг, 5 иргэнд нийт 10 цагийн хичээл орсон. Бичиг үсгийн сургалтыг нэг Багийн Засаг Дарга нартай хамтарч 4 багийн 7 иргэдийн ар гэрээр айлчлал хийж даалгавар өгч ажиллалаа. Үүний үр дүнд 3 иргэн танхимын сургалтыг 2 удаа авсан. Анхан шатанд 2, Дунд шатанд 3 Гүнзгий шатанд 2 иргэн хамрагдаж байна. | 90% |

| | | | | | | |
|----|---|---|-------------|--|---|------|
| | | боловсролыг дээшлүүлнэ. | | | <p>“Алхам алхмаар ” аяны мэдээллийг тухай бүрд нь Шинэжинст сумын насан туршийн боловсролын группэд байршуулж байна. “Миний эрхэмлэх үнэт зүйл, миний мэргэжил постер уралдаан”-д 9-р ангийн 5 сурагчийн постер, 8-р ангийн Эсээ бичлэг 2 сурагчдын бүтээлүүдийг холбогдох байгууллагад хүргүүлсэн. Дэлхийн усны өдөр, мазаалайн өдрүүдийг тохиолдуулан 6-9 ангийн сурагчдын дунд ханын сонин хийх уралдааныг 2 удаа зохион байгуулсан. Дунд ангийн 7 бүлэг оролцсон. Төрийн албан хаагчдад ҮЭ дарга Ц.Хуяг хөдөлмөрийн тухай хуулиар захиалгат сургалтыг 2023 оны 02 сарын 16 нд соёлын төвд нийт 54 хүнд хийв. Сумын эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтарч “Нандин холбоо” арга хэмжээн дээр “Эмэгтэйчүүд гэж хэн бэ” “Эмэгтэйчүүд гайхамшигт ертөнц” гэсэн лекцүүдийг уншлаа. Нийт 68 иргэн хамрагдсан. сурагчдад “Мөнгө, мөнгөний үнэ цэнэ”, “Санхүүгийн боловсрол” сэдвээр сургалт орсон. Дэлхийн мөнгөний долоо хоног Цахим сургалтад 20 сурагчдыг хамрууллаа. Мөн ХААН БАНК-тай хамтарч 7-9 ангийн нийт 58 Сургуулийн асран хамгаалагчийн дунд өртөөлчилсэн сургалтыг удирдамжийн дагуу явуулсан. Энэ үйл ажиллагаанд нийт 105 эцэг эх оролцлоо. 8-9 дүгээр ангийн 71 сурагчдад “Өөрийгөө таньж мэдэх” “Миний зан төлөв темперамент” “Сонирхлоо зөв тодорхойлох” “Үнэт зүйл ” гэсэн 4 багц сургалтыг зохион байгуулж явуулсан. Энэ жил Насан туршийн боловсролын 5 чиглэлээр нийт 40 төрлийн сургалтыг 1116 иргэнд явуулсан байна.</p> | |
| 28 | 2.4. Иргэдийн нийгмийн баталгааг хангах | 2.4.1. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн | 2021 - 2024 | | <p>Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний сайн дурын даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлүүлэх тухай хуулийг сурталчлах, хамрагдалтыг нэмэгдүүлэх, мөн ажил олгогчдын тоог нэмэгдүүлэх, тэдний гар утсанд “Нийгмийн даатгал” аппликейшнийг суулган өгч ашиглах зааврыг тайлбарлах, хэрэглээг нь нэмэгдүүлж, нийгмийн даатгалын цахим үйлчилгээ болон ач холбогдлыг таниулаж 4 удаа дөрвөн багруу явж сургалт хийж нийт</p> | 100% |

| | | | | | | |
|----|--|--|-------------|------|---|------|
| | | баталгааг хангана. | | | давхардсан тогоор 845 иргэн хамрагдлаа. жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд нийт 257 даатгуулагч хамруулсны 225 нь “Малчин” байгаа нь сайн дурын даатгалд хамрагдаж байгаа иргэдийн 90%-ийг эзэлж байна. 2023 оны жилийн байдлаар нийт Сайн дурын 257 даатгуулагчидтай гэрээ хийсэн. Үүнээс шинээр нийт 46 иргэнтэй сайн дурын гэрээ байгууллаа, Гэрээнд заасны дагуу төлөх шимтгэлийг тооцон авч 257 даатгуулагч хамруулж 2023 оны 11 дүгээр сарын 29-ны байдлаар 195 945 730 төгрөгийн орлого оруулахаас 178 765 841 төгрөг хуримтлагдсанаар 91 хувиар биелүүлээд байна. Эхийн 0-3 настай хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх шимтгэлд нийт 24 эхийг хамруулж жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөнд 10 784 510 төгрөгийн орлого оруулахаас 9 771 030 төгрөгийг хуримтлагдсанаар 90 хувиар биелүүлээд байна. Эхийн хүүхэд ээ асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлөх шимтгэлд нийт 20 эхийг хамруулж эхний хагас жилийн төлөвлөгөөнд 9,115,880 төгрөгийн орлого оруулахаас 8,293,100 төгрөгийг хуримтлагдсанаар 90 хувиар биелүүлээд байна. Эрүүл мэндийн даатгалд иргэдийг хамруулж 20,719,660 сая төгрөгийн орлого оруулахаас 256 даатгуулагчдыг хамруулж 23,856,600 төгрөгийн орлого хуримтлагдсанаар 115 хувиар биелүүлээд байна. | |
| 29 | | 2.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | 6сая | Энэ ажлын хүрээнд зорилтот бүлгийн иргэн Ц.Н –гийн нөхцөл байдлын талаар хамтарсан багаар ажиллаж 2 удаагийн хурлаар хэлэлцэн, бодитой, амьдралд нь нийцсэн шийдвэр гаргахыг зорьсон. Сумын Засаг дарга ажил олгогч аж ахуйн нэгжтэй ярилцаж тохирсны үндсэн дээр зорилтот бүлгийн 1 иргэний өөрийн биеийн чадамжийн онцлогт тохирсон ажлын байранд оруулж, цалинжуулж, хөдөлмөрлүүлж, ажилтай орлоготой болгосон. “Эрдэнэ Монгол” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд гэрээ байгуулж, орлоготой байх эх үүсвэр бүрэн шийдэгдсэн. | 100% |

| | | | | | | |
|----|--|-------------|---|--|---|------|
| 30 | 2.4.3. Ажилтай орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж 25-аас доошгүй иргэн байнгын болон түр ажлын байраар хангагдана. | 2021 - 2024 | Ажил олгогчдын санхүүгийн эх үүсвэр. | | Суманд үйл ажиллагаа явуулдаг бүх төрийн байгууллагын сул чөлөөтэй ажлын байранд 13 иргэн, Уул уурхайн гүйцэтгэгч Өрнөх үндэс ХХК-д 10 иргэнийг ажлын байраар хангаж, 2023 онд нийт 23 иргэн сул чөлөөтэй ажлын байраар хангагдсан. | 100% |
| 31 | 2.4.4. Ахмадын зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж тухайн ахмад настангуудын өрхийн орлогыг нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 0,9 сая төгрөг | | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчигээний төсөлд архивын мэргэжилтэй 1 ахмад настны төслийг хүлээн авч Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт хүргүүлэн, цалин олгож дэмжлэг олгосон | 100% |
| 32 | 2.4.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 31 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | | Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2023 онд 5 залуу малчин өрхийг хамруулан, 5 өрхийн хөдөлмөрийн насны 10 иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч 2 иргэн тус тус ажлын байрны санхүүгийн дэмжлэг авсан. | 90% |
| 33 | 2.4.6. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 2021 - 2024 | | | Хөгжлийн бэрхшээлтэй, сонсголгүй уг иргэн Н нь өөрийн 2 хүүхдийн 200000 төгрөг, халамжийн 290000 төгрөгөөс өөр өрхийн орлогогүй байсан бөгөөд өөр бусадтай харьцах харьцаагүй, нийгмээс тусгаарлагдсан олон жилийн давтамжтай үйлдэл гаргадаг байсныг өөрчилж, өөрийн биеийн чадамжийн онцлогт тохирсон ажлын байранд оруулж, цалинжуулж, хөдөлмөрлүүлж, ажилтай орлоготой болгосноор амар тайван амьдрах, нийгэмшүүлж, бусадтай харьцах байдлыг бий болгож өгсөнөөр үр дүнтэй ажлын нэг болоод байна. Мөн төрийн байгууллагаас сургуульд 1, ЗДТГ-т 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. | 90% |

| | | | | | | | |
|----|--|---|-------------|-------|--|---|-----|
| 34 | | 2.4.7. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүлийн гишүүдэд ээлтэй бодлого хэрэгжүүлж хүний хөгжил, хамгааллыг сайжруулна. | 2021 - 2024 | 500,0 | | <p>Гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, гэр бүлийн гишүүдэд ээлтэй бодлого хэрэгжүүлж хүний хөгжил, хамгааллыг сайжруулах чиглэлээр Гэр бүлийн хүчирхийллийн улмаас баривчлагдсан хүмүүсийн гэр бүлийн гишүүдэд 2 удаа, төрийн албан хаагч нарт нийт 140 гаруй албан хаагч нарт сургалт 1 удаа зохион байгуулсан. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 2 удаа ирж сургалт нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 68 өрхийн 120 гаруй иргэд хамрагдсан. Мөн нөлөөллийн ажлын хүрээнд "Гэр бүлээрээ мод таръя" арга хэмжээг зохион байгуулсан</p> <p>Хавсралт : 1 зураг</p> | 90% |
| 35 | | 2.4.8. Хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлнэ. | 2021 - 2024 | | | <p>Хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлэх зорилгоор Хүүхдийн баяр бол хүүхэд насны баяр баясгалан, өсвөр үеийнхний хязгааргүй боломжуудыг тэмдэглэх баяр бөгөөд Хүүхдийн эрхийг хамгаалах баярт өдрийг тохиолдуулан, ах дүүсийн хүрээлээр нь баг бүрдүүлэн тэмцээнд оролцуулж, удам судраа мэдэж, авах, ураг төрлөө судалж, танин мэдэх, зан төлөвшилд эерэг нөлөөлөл үзүүлэх, тэдний үе удмын харилцааг бэхжүүлэх зорилгоор "Ураг удмаа мэдь" сэдвийн хүрээнд уралдаан тэмцээнийг амжилттай зохион байгуулсан.5 ураг удам оролцож 1 дүгээр байранд Андиа, 2 дугаар байранд "Тарганыхан", 3 дугаар байранд "Цацагт" удмынхан шалгарлаа.</p> <p>Хавсралт : 1 файл</p> | 70% |
| 36 | | 2.4.9. Угийн бичиг хөтлөх аян зохион байгуулна. | 2021 - 2024 | 250,0 | | <p>Угийн бичгийг хөтлөх арга зүйн сургалтыг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас мэргэжилтэн ирж сургалтыг хийсэн ба нийт 68 өрхийн 120 гаруй иргэд хамрагдсан. Мөн "Ураг удмаа мэдь" сэдэвт уралдааныг хүүхдүүдийн дунд зохион байгуулж , ахан дүүс гэдгийг мэдүүлэх, эв эеийг эрхэмлэх зорилго агуулсан.</p> | 90% |

| | | | | | | | |
|----|---------------------------------------|---|-------------|--------|--|--|------|
| | | | | | | Хавсралт : 1 файл | |
| 37 | | 2.4.10. Иргэдэд эрүүл аж төрөх дадал хэвшилд сургах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоно. | 2021 - 2024 | 5 сая | | Эрүүл мэндийн төвөөс зорилтот бүлгийн 10 хүнд дархлаажуулах багц өгч, ар гэрийн асран хамгаалагч нарт асаргаа сувилгаа болон халамжийн хуулийн эрх зүйн мэдлэг олгох зөвлөгөөг гэрээр өгч ажилласан. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байранд Эрүүл мэндийн төвийн дарга Б.Хоролмаа нийгмийн ажилтан И.Ууганбаяр нар очиж бүтэн өнчин болон хагас өнчин охидуудад нөхөн үржихүйн хууль эрх зүйн боловсролыг олгох сургалт хийж, ариун цэврийн болон ахуйн хэрэглээний хэрэгслийг байрын багш Б.Ариунжаргалд хүлээлгэн өгсөн. Зорилтот бүлгийн харааны бэрхшээлтэй 3-р багийн иргэн Ж-гийн ар гэрт нь очиж урьдчилан сэргийлэх үзлэг хийж, 0-3 насны хүүхдүүдэд нь дархлаажуулах багц өгч тухайн ээжид нь ариун цэврийн хэрэглэл өгсөн. Хүний эрх эрх зүйн талаар эрүүл мэндийн байгууллагын хамт олонд ажлын байрны сургалтыг сумын хэсгийн төлөөлөгч цагдаагийн ахмад Б.Баасанжарал, цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням нар хийж, нийт 18 хүн хамрагдсан, Эртэч Шинэжинстчүүд, Хөдөлгөөн ба эрүүл мэнд намрын олон төрөлт спортын уралдаан тэмцээн зэрэг ажлуудыг зохион байгуулж нийт 1500 иргэн хамрагдсан. | 90% |
| 38 | 2.5. Соёлтой иргэн-Нийгмийг түүчээлнэ | 2.5.1. Сумын нийт ард иргэдийн дунд соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулна. | 2021 - 2024 | 3,5сая | | Уран бүтээлч нарын болон баг байгууллага ардын авьяастануудтай хамтарсан урлагийн тоглолт - 14 удаа нийт 1615 хүн хамрагдсан байна. Нийтийн цэнгээнт бүжиг – 30 удаа нийт 3130 хүн хамрагдсан байна. Кино үзвэр – 4 удаа нийт 160 хүүхэд хамрагдсан. Хурал зөвлөгөөн - 18 удаа нийт 1636 хүн хамрагджээ. Тэмцээн наадам - 6 удаа 213 хүн оролцсон. Бусад 18 удаа нийт 835 хүний үйл ажиллагаа зохион байгуулагдсан байна. хүүхдийн дууны уралдаан, Уран жиргээ уран уншлагын туралдаан, нутгийн зохиолчдын дууны уралдаан зэрэг уралдаан зохион | 100% |

| | | | | | | |
|----|---|-------------|-----------|--|---|------|
| | | | | | байгуулаад байна. | |
| 39 | 2.5.2. Соёлын биет ба биет бус өв, түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулж, ард иргэдэд сурталчилан таниулна. | 2021 - 2024 | 1,500,000 | | Орон нутаг судлах танхимыг бүрэн камержуулсан. Мөн Түүх соёлын дурсгалт газруудыг багийн дарга нар болон ойролцоох малчидтай хамтран ажиллах гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Орон нутгийн хамгаалалтад байдаг Шарилын овооны хоёр бунханг хайлсжууллаа. Хайлсжуулах ажлыг сумын СЭКЕРРЕСОРСУС МОНГОЛИА ХХК-ны санхүүжилтээр 1,500,000 төгрөгөөр уг газрыг хайлсжуулж ажиллаа. | 100% |
| 40 | 2.5.3. Соёлын бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан иргэдийг соён гэгээрүүлж, хандлагыг өөрчилж “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | 200,000 | | Бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээний хүрээнд хөгжмийн дугуйлан 17 хүүхэд, бүжгийн дугуйлан 80хүүхэд, Утга зохиолын дугуйлан 15 хүүхэд гэх мэт дуйгулангууд хичээллэж байна.. Мөн Уртын дууг хүүхэд залуучуудад сургах түгээн дэлгэрүүлэх залуу хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор Уртын дууны багш Д.Бямба, сумын уртын дууч Д.Ганбат нараар багшлуулан сургуулийн насны 10 хүүхдэд 3 дууг бүрэн зааж сургаад байна. | 100% |
| 41 | 2.5.4. Урлаг соёлын чанар хүртээмжийг дээшлүүлж, үйл ажиллагаа явуулах орчин нөхцөл сайжруулна. | 2021 - 2024 | 20,0 сая | | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ямаха даралтат хөгжим 1 ширхэг, ятга 6 ширхэг, ёочин 2 ширхэг, морин хуур 5 ширхэг, үкүлэлэ 10 ширхэг, хуучир 1 ширхэг, баян хуур 1 ширхэг хөгжмийн зэмсэг худалдан авсан | 100% |
| 42 | 2.5.5. Иргэдийн ном унших дадал | 2021 - | 768,000 | | Номын сангийн дэргэдэх Утга зохиолын дугуйланг ажиллуулахаас гадна ЕБС-ийн номын сантай хамтран | 100% |

| | | | | | | | |
|---------------------------------|--|--|-------------|----------|--|---|-----|
| | | хэвшлийг нэмэгдүүлж, номын сан болон орон нутаг судлах танхимын үйл ажиллагааг сайжруулна. | 2024 | | | Хүүхэд залуучуудын ном унших дадал хэвшлийг сайжруулах зорилгоор сургуулийн номын сантай хамтран 6-9 дүгээр ангийн хүүхдэд ангиар нь хуваарь гарган 3 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 1-ний хүртэл хугацаанд танхимаар ном уншуулж байна. Мөн дунд ангийн сурагчдын дунд Уран жиргээ—Уран уншлагийн уралдааныг 2 үе шаттай зохион байгууллаа. Сургуулийн сурагчид болон ард иргэд давхардсан тоогоор 150 гаруй иргэнд 750 гаруй ном гэрээр олгон үйлчилсэн байна. | |
| 3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 43 | 3.1. Газар тариалангийн салбарын үйл ажилагааг дэмжиж, тариалалт, ургац хураалтыг нэмэгдүүлнэ. | 3.1.1. Төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлын үр дүнг тооцож цаашид төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ | 2021 - 2024 | | | Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаанд тус сумаас тариаланч Т.Батжаргал, З.Олонбаяр, Ц.Тэгшзаяа нар нутгийн хөрсөнд ургасан хүнсний ногоо, жимс жимсгэнэ зэрэг сумын брэнд бүтээгдэхүүн болох аянчин, жинчин зэрэг бүтээгдэхүүнүүдээр оролцсон. Тус сумын тариалан эрхлэгч Т.Батжаргал аймгийн тэргүүний тариаланч өрхөөр шалгарч шагнагдсан. Мөн 19 тариалан эрхлэгч өрхүүд Эрдэнэмонгол ХХК-тай гэрээ байгуулан хүнсний ногоо нийлүүлсэн. | 90% |
| 44 | | 3.1.2. Нутгийн брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлнэ | 2021 - 2024 | 20000000 | | Уртын гол багийн малчин Д.Ганзориг нь Ингэний хоормог, сүү, цагаан идээ үйлдвэрлэх төслөөр 20 сая төгрөгийн зээл авсан. Тус санхүүжилтээр 6 төрлийн уут, хаяг, шошго, 700 литрийн хөлдөөгч, гялгар уутны ам наагч зэрэг сав баглаа боодол, тоног төхөөрөмжийг худалдан авч ингэний хоормог, сүү, ямааны сүү, аарц, говийн болон хэвийн ааруул, хорхой болон чипсэн ааруул, шар тос, өрмөн тос, шимийн архи, тараг зэрэг 12 төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулж байна. Ингэний хоормогоо сум орон нутагтаа төдийгүй Дархан, Улаанбаатар хот руу захиалгын дагуу нийлүүлдэг. | 90% |

| | | | | | | |
|----|---|-------------|----------|--|--|------|
| 45 | 3.1.3. Газар тариалан эрхлэгчдийг дэмжих, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг лизингийн болон зээлийн бодлогоор дэмжинэ. | 2021 - 2024 | 80000000 | | 2022 онд эхийн голын тариалан эрхлэгчдэд анжистай трактор Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр авч нийлүүлсэн. | 90% |
| 46 | 3.1.4. Стандартын шаардлага хангасан хүлэмж, зоорийн тоог нэмэгдүүлэн ашиглалтыг сайжруулна. | 2021 - 2024 | | | Тус сумын цэцэрлэгийн хамт олон нь Баянхонгор аймгийн Хүнс Хөдөө Аж Ахуйн газарт хүсэлт хүргүүлсэнээр нарийн ногоо тариалах хүлэмжтэй болсон ба хавар ногоо тарихаар төлөвлөн ажиллаж байна. Мөн уртын гол 2 дугаар багийн тариаланч Ц.Мөнхбат аймгийн ХХАА-н газартай гэрээ байгуулан 4х6 хэмжээтэй хүлэмж ирэх хавар хүнсний нарийн ногоо тариалахаар авсан. Хавсралт : 1 зураг | 100% |
| 47 | 3.1.5. Сумын хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн сумын хөрсөнд тариалсан бүтээгдэхүүнээр хангахыг зорьж, Эхийн гол, Уртын гол болон бусад булаг шандыг түшиглэн тариалалтыг | 2021 - 2024 | | | Энэ онд 19 өрхийн тариаланч сумын хэмжээнд нийт 4.5 га талбайд тариалалалт хийсэн. Үүнээс төмс 0.66 га, шар манжин 0.195 га, хүрэн манжин 0.075 га, лууван 0.2 га, сонгино 0.14 га, өргөст хэмх 0.52 га, улаан лооль 1.24 га, тарвас 0.19 га, амтат гуа 0.655 га, чинжүү 0.165 га, газрын алим 0.4 га-д, эмийн ургамал лидэр 0.05 га, гүргэм 0.01 га-д тариалсан. Нийт 56 тн ургац хураан авсан. Үүнээс төмс 4.21 тн, шар манжин 0.89 тн, хүрэн манжин 0.36 тн, лууван 1.93 тн, сонгино 0.345 тн, өргөст хэмх 6.94 тн, улаан лооль 24 тн, халуун чинжүү 1.378 тн, тарвас 3.11 тн, амтат гуа 8.5 тн, газрын алим 5.305 тн, гүргэм 0.005 тн, лидэр 0.01 тн ургац хураан авлаа. | 90% |

| | | | | | | |
|----|---|---|-------------|--------|---|-----|
| | | нэмэгдүүлнэ. | | | Хавсралт : 5 зураг | |
| 48 | 3.2. Мал эмнэлгийн аж ахуйн нэгжийг чадавхжуулж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн эрүүл бүс статусаа бататгана. | 3.2.1. . Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлж эрүүл бүс статусаа бататгана. | 2021 - 2024 | 485000 | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг улирал, хагас жилээр тайлагнан гүйцэтгэлийг цахим системд оруулсан. Энэ онд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 5 төрлийн дархлаажуулалтанд Шөвөг яр- 1000, Дотрын халдварт хордлого- 3000, Боом- 400, Галзуу – 2400, Цусан халдвар – 1000 нийт 9800 хамрагдахаас 9800 мал хамрагдаж гүйцэтгэл. 100 хувьтай дархлаажуулалтад хамрагдлаа. Мал эмнэлгийн нэгдсэн цахим системд 9800 толгой мал сүргийг төлөвлөн оруулж гүйцэтгэлийг бүрэн оруулсан. Нийт дархлаажуулалтад хамрагдсан малчин өрхийн .30 хувь ба 14 малчин өрхөөр явж хяналт тавьж ажиллалаа.. Малчин өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрийн бичилтийг тарилгын жагсаалттай тулган үзлээ. Шимэгч өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд “Бодиос-Кашмер” үйлчилгээний нэгж туулгалтад – 10250, угаалганд-30100, боловсруулалтанд - 10100 толгой мал амьтан, “Зах гурван бамбуу” үйлчилгээний нэгж угаалганд- 40100, туулгалтанд- 10250, боловсруулалтад – 10100 толгой мал амьтныг хамруулахаар хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Мал эмнэлгийн нэгдсэн цахим системд шимэгчтэх өвчнөөс сэргийлэх, эмчлэх арга хэмжээний гүйцэтгэлийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд тухай бүр оруулан ажиллалаа. Мал эмнэлгийн тасгийн 2 мэргэжилтэн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шийдвэрүүлж авсан Дук автомашинаар Мал эмнэлгийн тасгийн 2 мэргэжилтэн 09, 10 дугаар сард “Цармын цагаан сувд” хоршооны 36 малчин өрхийн 9980 мянган малыг хамруулан технологийн дагуу угаалгын ажлыг гүйцэтгэлээ. Мөн 07 дугаар сард “Бодиос-Кашмер” ХХК-ийн малын эмч, туслах ажилтаны хамт хоршооны өрхүүдээр явж мотопомпоор малыг шүршиж угааж угаалганд хамрууллаа. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хавар, намар нийтдээ 501 үхэр хамрагдлаа. Зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс | 90% |

| | | | | | | |
|----|---|---|-------------|-----------|--|------|
| | | | | | шийдвэрлүүлэн 485000 төгрөгний шатахуун зарцууллаа. | |
| 49 | | 3.2.2. Малын шилжилт хөдөлгөөн болон малын гаралтай бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулна. | 2021 - 2024 | 79200 | Сумын хэмжээнд 2 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж сумын Засаг дарга, аймгийн Мал эмнэлгийн газартай гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ оны 02 дугаар сарын 4,5-ны өдөр зохион байгуулагдсан малчид, төлчдийн зөвлөгөөнөөр аймаг, сумын Засаг даргын “Малын шилжилт хөдөлгөөнийг хориглох тухай” захирамжийг танилцууллаа. Шилжилт хөдөлгөөнөөр өөр аймгаас ирж байгаа адуунд бичигдсэн цахим гэрчилгээг хянан зөвшөөрөх төлөв оруулан ирэхэд нь хүлээн авч халдваргүйтгэл хийн захирамжид заасан заалтын дагуу адууны нийлүүлгийн болон хачгийн халуун өвчний шинжилгээний дээж аван аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэн ажилласан. Сумын хэмжээнд нийт 10 байршлаас 40 адуу ирсэнээс 10 дээж цуглуулан аймгийн Мал эмнэлгийн газрын лабораторид өгч шинжлүүлсэн. Шинжилгээний хариу сөрөг гарсан. | 90% |
| 50 | | 3.2.3. Мал эмнэлгийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай эм бэлдмэлийн нөөц бүрдүүлнэ. | 2021 - 2024 | 5.000.000 | Гамшгаас хамгаалахад бэлэн байдлын нөөц бүрдүүлэн халдваргүйтгэлийн бодисын нөөц 300кг, халдвар хамгааллын хувцас - 100 ширхэгийн нөөц тэй байна. | 90% |
| 51 | 3.3. Малын чанар ашиг шимийг сайжруулах | 3.3.1. Малын чанар, ашиг шимийг сайжруулах малын тоог чанарт шилжүүлж “Монгол мал” “Монгол малчин”, “Шинэ хөдөө” үндэсний хөтөлбөрийг | 2021 - 2024 | | Монгол мал хөтөлбөрийн 2 дахь үе шат 2016-2021 онд хэрэгжиж дууссан.Энэ шатанд малын ашиг шимийг дээшлүүлэх,чанарыг сайжруулах ажлуудыг гол зорилгоо болгож ажиллалаа.Жил бүр бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтанд хамруулж ашиг шимийн түвшинг тогтоож ирлээ.2023 онд 780 толгой бог малын хээлтүүлэгч,Залаажинст-Эдрэн үүлдрийн цөм сүргийн 263 толгой хээлтэгчийг хамрууллаа.Тогтвортой ноос ноолуур төслийн санхүүжилтээр ямааны ноолуурыг ноолуурын үйлдвэрт шинжлүүлэхэд дунджаар 14,9 микрон болж нарийссан таатай дүн мэдээ гарлаа.Монгол малчин | 100% |

| | | | | | | |
|----|--|---|-------------|--------|---|------|
| | | хэрэгжүүлнэ. | | | хөтөлбөрийн хүрээнд малчдыг төсөл хөтөлбөрт хамруулах, шагнал урамшуулалд тодорхойлох, бүтээгдхүүний урамшуулалд хамруулахад анхаарч ирлээ. 2021, 2022, 2023 онуудад жил аймгийн аварга малчнаар журмын дагуу 3 малчныг тодорхойлон шагнууллаа. Мал сүргээ чанаржуулах талаар идэвх санаачилга гарган ажиллаж байгаа малчдыг малжуулах хөтөлбөр хамруулж байна. 2023 онд 5 малчин хамрагдлаа. Нийт санхүүжилт 15 сая төгрөг зарцууллаа. | |
| 52 | | 3.3.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт болон үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, ажлын байр нэмэгдүүлэн, бренд бүтээгдэхүүн бий болгоно. | 2021 - 2024 | | Мал аж ахуйн бүтээгдхүүний үйлдвэрлэл, худалдаа эрхлэгч малчдын хоршоодууд Засгийн газраас олгож байгаа хүүгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан бүтээгдхүүнийг авч боловсруулах, бүтээгдхүүн болгож зах зээлд гаргах ажлыг хийж байна. Баянговь цагаан ямаат хоршоо ноолууран бүтээгдхүүнийг үйлдвэрлэж Европийн зах зээлд нийлүүлж байна. Тогтвортой ноос, ноолуур төслийн үр дүнд бий болсон Цармын цагаан сувд хоршоо ноолуурыг самнаж дэлхийн зах зээлд гаргаж байна. Залаа шинэ эргэлт хоршоо Засгийн газраас олгож байгаа хүүгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж ноолуур, ноосыг авч үндэсний үйлдвэрүүдэд нийлүүлж байна. | 100% |
| 53 | | 3.3.3. Төсөл хөтөлбөрийн хүрээнд малжуулах ажлыг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | 25 сая | Тус сумд малжуулах арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон ажилласан. Ажлын хэсгийн ахлагчаар сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасгийн дарга, Мал эмнэлэгийн тасгийн дарга, Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хөдөөгийн 3 багийн Засаг дарга нар томилогдон ажлыг хамтран зохион байгуулсан. Ажлын хэсгийн Нарийн бичгийн дарга 2023 оны 09 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Малжуулах арга хэмжээнд хамруулахаар шийдвэрлэгдсэн 5 залуу малчин | 100% |

| | | | | | | |
|----|---|--|-------------|----------------------------------|--|------|
| | | | | | <p>өрхийн тэргүүлэгч, мөн малаа худалдан борлуулагч иргэдийн төлөөллүүд, батлан даагч иргэдүүдтэй мал худалдах, худалдан авах гэрээ, малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэгийн гэрээ, батлан даалтын гэрээ зэрэг гэрээнүүдийг бүрэн хийсэн. Малчин өрхийг малжуулах санхүүгийн дамжлэгийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийг сумын Засаг даргатай байгуулсан. Ажлын хэсгийн дарга гишүүд 2023 оны 09 дүгээр сарын 11-ний оройны 18:30 цагт Уртынгол 2 дугаар багийн малчин Ө.Дэлгэрсайханд очиж залуу малчин Л.Очирбатад 41 ямаа, 41 ишиг нийт 82 толгой мал, 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өглөөний 08:20 цагт Уртынгол 2 дугаар багийн малчин Ч.Бямбаагийн дүнд очиж залуу малчин Б.Энхжаргалд эм ямаа-35, эр ямаа-20, ишиг-10 нийт 65 толгой мал, 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 13:40 цагт Эрдэнэшанд 3 дугаар багийн малчин О.Чимэддагвынд очиж залуу малчин Ц.Баянжавын дүнд эм ямаа 36, ишиг-35 нийт 71 толгой мал, Эрдэнэшанд 3 дугаар багийн малчин Ж.Батсайханы дүнд очиж залуу малчин Д.Лувсандоржид эм ямаа 50, ишиг-25 нийт 75 толгой мал, Зараа 1 дүгээр багийн малчин Г.Оюунбаатарын дүнд очиж Уртынгол 2 дугаар багийн малчин П.Нямсүрэнгийн хэсэг эм ямаа 45, ишиг 22 нийт 67 толгой малыг тус тус хүлээлгэн өглөө. Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор "Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг үйл ажиллагаа"-ны Малчдыг малжуулах арга хэмжээг Шинэжинст суманд хэрэгжүүлэхээр баталсан. Үүний хүрээнд 5 залуу малчин өрхөд нийт 360 ишиг, ямаа толгой малаар малжуулан ажиллаа.</p> <p>Хавсралт : 1 файл</p> | |
| 54 | 3.4. Үйлдвэржилтийн бодлогын судалгаан дээр | 3.4.1. Үйлдвэржилтийн бодлоготой уялдуулж орон | 2021 - 2024 | Хоршоо хөгжүүлэх сангаас 140 сая | "Цармын цагаан сувд" хоршооны сумын брэнд болох цагаан ямааны үүлдэр угсааг сайжруулах, "Залаажинст" үүлдрийн цөм сүрэг бүрдүүлэх зорилготой "Залаагийн сувд" төсөлд Хоршоо хөгжүүлэх сангаас 40 сая төгрөг, "Бат Богд дулаан" | 100% |

| | | | | | | | |
|----|--|--|-------------|-------------------------------------|--|---|--|
| | үндэслэн сумын үйлдвэржилтийн бодлогыг тодорхойлж зах зээлийг судлах, цаашид эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх | нутгийн чиглэлийг тодорхойлж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгож ажлын байрыг нэмэгдүүлнэ. | | төгрөг | | ХХК-ийн албан байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдсэн халаалт буюу дулаан хангамжийг сайжруулах төсөлд 40 сая төгрөг, иргэн Д.Ганзоригийн говь нутгийн ааруул, цагаан идээ, ингэний хоормог, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах төсөлд 20 сая төгрөг, Ж.Отгонбаярын "Авто машины агрегат завсар" төсөлд 20 сая төгрөг, Ш.Болормаагийн "Талх, нарийн боов" үйлдвэрлэх төсөлд 20 сая төгрөг, нийт 140 сая төгрөгийн зээлийг 2023 оны 08 дугаар сард олгож зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих орон тооны бус зөвлөл 11 сард хяналт тавьж ажиллаа. Дээрх зээлийг олгосноор суманд шинээр 5 ажлын байр нэмэгдсэн. Хавсралт : 1 файл | |
| 55 | | 3.4.2. Ингэ ямааний сүү хуурайшуулах үйлдвэр байгуулах мөн арьс шир, нэхий боловсруулах анхан шатны цехийн үйл ажиллагааг сайжруулан байнгын ажиллагаатай болгоно. | 2021 - 2024 | Сум хөгжүүлэх сангаас 19 сая төгрөг | Арьс шир, нэхий боловсруулах анхан шатны цех нь 2020-2021 онд үйл ажиллагаагаа тогтмол явуулж эрчимтэй сайжруулж байсан хэдий ч төсөл хэрэгжүүлэгч иргэн Ш.Ганбат нь өөр ажилд шилжин ажилласнаас үүдэн цехийн үйл ажиллагаа одоогоор зогсонги байна. Хавсралт : 3 зураг | 50% | |
| 56 | 3.5. Санхүү эдийн засгийн хүндрэлийг тооцож, эдийн засгийг тогтвортой байлгахад | 3.5.1. Татварын хууль тогтоомжийг сурталчилан хэрэгжилтэд хяналт тавих, улс орон нутгийн | 2021 - 2024 | Үйл ажиллагаагаар | Улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр жигд ханган биелүүлэх, татварын бааз суурийг нэмэгдүүлэх зорилгоор татварын орлого бүрдүүлдэг албан хаагч нартай хамтран ажиллалаа. Энэ оны эхний 5 сард 91260.0 мян.төг-ийн татварын орлого төвлөрүүлэхээс 2015413.5 мян.төг-ийн орлого төвлөрүүлж орлогын төлөвлөгөөний тэнцлийг 220%-аар ханган биелүүлсэн. | 100% | |

| | | | | | | | |
|----|----------|---|-------------|----------------------|--|--|------|
| | анхаарна | төсвийн орлогыг татварын нэр төрөл бүрээр жигд ханган биелүүлнэ. | | | | | |
| 57 | | 3.5.2. Мэдээ, мэдээллийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны болон худалдан авах ажиллагааны цахим хэрэглээг иргэдэд сурталчлан таниулж, “Тунгалаг санхүү” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | хөрөнгө шаардахгүй | | Төсөвт албан газрууд шилэн дансны мэдээлэлийг сар бүрийн 08 ны дотор нягтлан бологч нар хариуцан байршуулж байна. Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлтийг албан тоотоор хүргүүлэн ажиллаж байна Хавсралт : 1 файл | 100% |
| 58 | | 3.5.3. Байгууллагуудын санхүүгийн сахилга батыг сайжруулж, ажилчдыг чадавхижуулан стандартын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангана. | 2021 - 2024 | 44350000 | | Засаг даргын Тамгын газар 41550000 төгрөгөөр, Иргэдийн төлөөлөгчдийн хурал 2800000 төгрөгөөр багаж техник хэрэгсэл авч төрийн албан хаагчдыг шаардлага хангасан техник хэрэгслээр ханган ажилласан Хавсралт : 1 файл | 100% |
| 59 | | 3.5.4. Төрийн өмчийн барилга | 2021 - 2024 | хөрөнгө зарцуулахгүй | | Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг хагас жил, бүтэн жилээр тоолж нягтлан бодох бүртгэлд тусган ажиллаж | 100% |

| | | | | | | | |
|------------------------------|---|---|-------------|--|--|--|------|
| | | байгууламж, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулан хяналт тавина. | | | | байна | |
| 60 | | 3.5.5. Төсөл хөтөлбөрүүдийг судалж гадаад харилцааг идэвхжүүлэн оновчтой хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана. | 2021 - 2024 | Хандив тусламжийн орлого 300,0 сая цэвэр усны байгууламж ? | | Уул уурхайн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн Эрдэнэ монгол Баян хөндий төслийн хүрээн ундны усны байгууламжтай болсон. Хандив тусламжийн орлогыг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж хувиарлан ИТХ-аар батлуулсан | 90% |
| 4. ДӨРӨВ. Засаглалын бодлого | | | | | | | |
| 61 | 4.1. Төрийн албаны үйлчилгээг түргэн шуурхай болгож, иргэдийг төрийн нэгдсэн бодлого удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай хариуцлагатай, хүртээмжтэй | 4.1.1. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн | 2021 - 2024 | | | Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнг тооцож, жилийн эцсээр 40 хүртэлх хувийн урамшуулал олгож, ажиллаж байна.Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулахтай холбогдуулж Засаг даргын Тамгын газар байгууллагын зорилтодоо “Угтах үйлчилгээний стандарт”-ыг хэрэгжүүлж ажилласан. Төр, иргэний хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор албан хаагчдад хуваарь гарган ажилласан. Үүний үр дүнд ажилчдын цагийг давхар бүртгэх, иргэнд түргэн шуурхай үйлчлэх давуу талууд бий болсон. Ёс зүйн зөрчил гаргасан 1 ажилтантай Ёс зүйн зөвлөлийн дарга биечлэн уулзаж, арга хэмжээ авч ажиллаж байна. Багш ажилчдын улирлын үр дүнг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга | 100% |

| | | | | | | |
|----|--|---|-------------|--|---|------|
| | хүргэх нөхцлийг бүрдүүлж, төрийн албанд ёс зүй, чадахуйн зарчмыг | албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана. | | | хариуцлагыг шалгуур болгон үнэлж байна. Ёс зүйн алдаа дутагдал гаргасан албан хаагчыг ёс зүйн зөвлөлийн хурлаар оруулан алдаа дутагдалыг засаж хариуцлага хүлээлгэн хэвшсэн. | |
| 62 | төлөвшүүлж, үйл ажиллагааны илт тод байдлыг сайжруулна. | 4.1.2. Чадварлаг, хариуцлага, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлнэ. | 2021 - 2024 | | Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнг тооцож, жилийн эцсээр 40 хүртэлх хувийн урамшуулал олгож, ажиллаж байна.Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулахтай холбогдуулж Засаг даргын Тамгын газар байгууллагын зорилтодоо “Угтах үйлчилгээний стандарт”-ыг хэрэгжүүлж ажилласан. Төр, иргэний хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор албан хаагчдад хуваарь гарган ажилласан. Үүний үр дүнд ажилчдын цагийг давхар бүртгэх, иргэнд түргэн шуурхай үйлчлэх давуу талууд бий болсон. Ёс зүйн зөрчил гаргасан 1 ажилтантай Ёс зүйн зөвлөлийн дарга биечлэн уулзаж, арга хэмжээ авч ажиллаж байна. | 100% |
| 63 | | 4.1.3. Төрийн үйлчилгээний операторын үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлэх замаар төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлж, | 2021 - 2024 | | Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд shinejinst.gov.mn веб сайт, Шинэжинст ЗДТГ фэйж(410like, 542followers), Shinejinst shinejinst (1000friend) фэйсбүүк хаяг нээн тус бүр 3 сошиал медиагаар иргэдэд мэдээлэл хүргэж ажиллаж байна. Жилийн хугацаанд онцлох үйл явдлын 20 зурган мэдээ, видео бичлэг 2, постер 7, зарын чанартай 20 мэдээг нийтэлж ажилласан. Мөн жилийн эцсийн байдлаар нийт 10 төрлийн үйлчилгээ, 210 лавлагааг операторын эрхээр, давхардсан тоогоор 125 хүнд имонголиа нээж, нууц үг солих, бүртгэлтэй утасны дугаар солих үйлчилгээ үзүүлж, ажилласан байна. Үр дүнтэй 100 хувь Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд shinejinst.gov.mn веб сайт, Шинэжинст ЗДТГ фэйж(410like, 542followers), Shinejinst shinejinst (1000friend) фэйсбүүк хаяг нээн тус бүр 3 сошиал медиагаар иргэдэд мэдээлэл хүргэж ажиллаж байна. Жилийн хугацаанд онцлох үйл явдлын 18 зурган мэдээ, видео бичлэг 2, постер 7, зарын чанартай 20 мэдээг нийтэлж ажилласан. Мөн жилийн эцсийн байдлаар нийт 10 | 100% |

| | | | | | | |
|----|--|---|-------------|-------------|---|------|
| | | бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ. | | | төрлийн үйлчилгээ, 210 лавлагааг операторын эрхээр, давхардсан тоогоор 125 хүнд имонголиа нээж, нууц үг солих, бүртгэлтэй утасны дугаар солих үйлчилгээ үзүүлж, ажилласан байна. Хавсралт : 1 файл | |
| 64 | | 4.1.4. Мэргэжлийн болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран Сумын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулж батлуулна. | 2021 - 2024 | | Мэргэжлийн болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран Сумын хөгжлийн мастер төлөвлөгөөг хэлэлцэж байна. | 30% |
| 65 | | 4.1.5. Төрийн байгууллагуудын авто машины парк шинэчлэлтийг хийнэ. | 2021 - 2024 | 148,800,000 | Сумын эрүүл мэндийн төвд "Эрдэнэ монгол" ХХК-аас 80,000,000 сая төгрөг УАЗ Фурган авто машин ОНХС Мал эмнэлэгийн дук машиныг 68,800,000 авто машины парк шинэчлэлтийг хийж хүлээлгэн өгсөн байна Хавсралт : 1 зураг | 100% |
| 66 | | 4.1.6. Авилга ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэн бүх нийтийн хандлагыг өөрчилнэ. | 2021 - 2024 | | Уул уурхайн ажиллаж байгаатай холбогдуулан Газрын даамал – Иргэдэд газар өмчлүүлэх тухай хууль болон Газрын тухай хуулийн талаар, Байгаль орчны хяналтын улсын байцаагч – Ашигт малтмалын тухай хуулийн талаар тус тус нийт 8 удаагийн хурал хэлэлцүүлгээр мэдээлэл хийж ажилласан. Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар мэдээллийг байгууллагын цахим хуудсанд шэйр хийж, иргэдэд түгээж байна. Мөн холбогдох гарын авлага, мэдээллийг мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. 2019-2022 оны ОНХС-ын хөрөнгөөр хийсэн ажлын талаар АТГ-т гомдол гарч Мөрдөгчийн мэдэгдэл ирсний дагуу холбогдох албан тушаалтнууд АТГ-т очиж мэдүүлэг | 90% |

| | | | | | | |
|----|---|-------------|-----------------|--|--|------|
| | | | | | өгсөн. АТГ-аас Үнэлгээний хорооны гишүүд болон Тендерийн баримт бичгийг шалгаж, холбогдох албан тушаалтнуудад арга хэмжээ авч ажилласан. Сумын албан ёсны вэб сайт shinejinst.bkh.gov.mn хаягт төсвийн мэдээллийг Санхүү албаны тухайн жилд батлагдсан төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл зэрэг мэдээллийг олон нийтэд ил тод байлгах үүднээс сайтад байршуулан ажиллаж байна. Hural.mn сайтад төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг байршуулдаг. Сумын фэйжид ОНХС-н мэдээлэл, төсөв санхүүгийн мэдээллийг тухай бүр нийтэлдэг. Хавсралт : 1 файл | |
| 67 | 4.1.7. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж иргэдэд эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 2021 - 2024 | | | Хууль, эрх зүйн мэргэжилтэн нь бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд төрийн албан хаагчидтай хамтран “Хууль зүйн мэдээллийн цаг”-ийг сумын төвд 03 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 2 сарын хугацаатайгаар нийт 18 удаагийн сургалтыг долоо хоногийн Пүрэв гараг бүр бусад төрийн албан хаагчтай хамтран зохион байгуулсан. Хавсралт : 1 файл | 100% |
| 68 | 4.1.8. Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран төрийн албан хаагчдыг орон сууцжуулах ажлыг эхлүүлнэ. | 2021 - 2024 | | | Хэрэгжээгүй | 0% |
| 69 | 4.1.9. Сумын | 2021 - | 84,9 сая төгрөг | | Эрүүл мэндийн больницын барилгын их засварын ажил | 90% |

| | | | | | | |
|----|---|-------------|--|--|--|------|
| | Спорт заал, Эрүүл мэндийн төвийн ажилчдын барилгуудад их засвар хийх , ЗДТГазрын барилгыг шинээр барих ажлыг хийнэ. | 2024 | | | 2023 онд гэрээгээр хийгдэх 50,0 сая төгрөгийн ажил бүрэн хийгдсэн. Нутгийн удирдлагын ордон барих ажлын зураг төсөв хийгдэж байна. | |
| 70 | 4.1.10. Сумын төв доторх 2 км хатуу хучилттай зам тавих ажлыг эхлүүлнэ. | 2021 - 2024 | | | Хэрэгжээгүй | 0% |
| 71 | 4.1.11. Төрийн албаны мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, хүний нөөцийг чадавхижуулна. | 2021 - 2024 | | | Төрийн албаны мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх чиглэлээр зуны 03 сарын хугацаанд "Эрдэнэ Монгол" ХХК-тай хамтран оюутан залуусыг дадлагажуулах хөтөлбөрийг зохион байгуулсан. Оюутнууд төрийн үйл ажиллагаатай танилцах, цаашид ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх талаар зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, албан хаагчид нэг оюутан хариуцаж дадлагажуулж ажилласан. Хүний нөөцийг чадавхжуулж ажиллахын хүрээнд албан хаагчдын сургалт сурталчилгааны томилолтын зардлыг өгч ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар нийт 4,232,400 төгрөгийг ажилчдын сургалтын зардалд зарцуулсан байна. Үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулж ажиллахын тулд Сумын цахим вэб сайт /shinejinst.bkh.gov.mn/ болон Фэйсбүүк фэйж нээн /shinejinst Shinejinst, Шинэжинст ЗДТГ фэйж/ Төрийн байгууллагаас зохиогдож буй үйл ажиллагаа, төсөв санхүүгийн талаарх ажлуудыг олон нийтэд ил тод байршуулан ажиллаж байна. Төрийн цахим үйлчилгээний газар байгуулагдсантай холбогдуулан Төрийн үйлчилгээний операторын орон тоог 2023 оны 01 сарын 02-ны Б/02 тушаалаар батлан ажиллаж байна. Мэргэжлийн боловсон | 100% |

| | | | | | | |
|---------------------------------|--|--|-------------|--|--|------|
| | | | | | хүчнийг чадавхжуулахын тулд 2023 оны 04 сарын 18, 19-ний өдрүүдэд ажил, мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө авах сургалтанд хамруулсан. Ингэснээр ажилтан олон нийтийн хурал зөвлөгөөний өдрүүдэд ард, иргэд болон төрийн албан хаагчдад имонголиа хэрхэн нээх, лавлагаа тодорхойлолт хэрхэн авах талаар мэдээлэл, зөвлөгөө хийж ажиллаж байна. | |
| 72 | | 4.1.12. Эхийн голыг эрчим хүчээр хангах | 2021 - 2024 | | Хэрэгжээгүй | 0% |
| 73 | 4.2. Архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг хангаж албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахимжуулна. | 4.2.1. Төрийн байгуулагуудын архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд архивын баримтын нягтруулсан шүүгээтэй болсон байна. | 2021 - 2024 | Нягтруулсан шүүгээ 2-ийг 2500 төгрөгөөр байгууллагын төсвөөс, 1870 00 төгрөгөөр Хамгаалалтын хайрцаг, баримтын хавтас авсан байна. | Байгууллагын 2001-2022 оны баримтын нэгдсэн тооллогыг явуулж баримт бүрийг хуудсаар нь тоолж нүүр, ашиглалтын, баталгааны хуудасыг засж янзлах шаардлагатай баримтуудыг засаж нэгдсэн мэдээг төрийн архивын тасагт хүргүүлсэн. Нийт 1064 баримтын 44825 хуудас баримттай байна. Засаг даргын Тамгын газар 1996-2022 оны баримтын тооллогыг явуулж баримтын хуудас бүрийг нягтлан шалгаж тоолов тэмдэглэгээ хийж дүн мэдээг төрийн архивт хүргүүлээд байна. Байгууллагын архивт 6 нягтруулсан шүүгээ байршуулж 1996-2022 оны 312261 хуудас бүхий 2964 хадгаламжийн нэгж байгууллагын архивт байна Хавсралт : 5 зураг | 100% |
| 5. Тав: Ногоон хөгжлийн бодлого | | | | | | |
| 74 | 5.1. Байгаль орчныг хамгаалах байгальд үзүүлэх сөрөг нөлөөллөөс | 5.1.1. Худаг уст цэг гаргах, шаардлагатай цэгүүдэд уст цэгийн хайгуул хийнэ. | 2021 - 2024 | 21,0 сая | Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх ажил дээр 21,0 сая төгрөгийн гэрээ байгуулан Зараа 1-р багийн нутаг Цагаан товгор, Уртын гол 2-р багийн нутаг Шивээ, Зээрэнгийн тал гэсэн газруудад уст цэгийн хайгуул хийж ус байгааг тогтоосон | 100% |

| | | | | | | | |
|----|---|--|-------------|-------------|--|--|------|
| 75 | урьдчилан сэргийлэх, байгаль орчны бодлогыг төлөвлөн хэрэгжүүлнэ. | 5.1.2. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн эвдрэлд орсон доройтсон газрыг нөхөн сэргээнэ. | 2021 - 2024 | | | хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтлыг бууруулах зорилгоор 2 аж ахуйн нэгж байгууллагад шаардлага хүргүүлж ажилласан. Нэг аж ахуйн нэгж байгууллага нь тухайн 0,2 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж ажилласан. 2023 онд хайгуулын үйл ажиллагааг 3 тусгай зөвшөөрөл эзэмшигч өрмийн үйл ажиллагаа явуулж, нөхөн сэргээлийг хийж хүлээлгэн өгсөн. Энэ онд өөр нөхөн сэргээлт хийх газар төлөвлөгдөөгүй | 90% |
| 76 | | 5.1.3. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилан таниулж стандарт хэм хэмжээг мөрдүүлнэ. | 2021 - 2024 | | | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдсэн байгууллага, аж ахуйн нэгж иргэд мод тарьж буйгаа албан ёсны мэдээллийн эх үүсвэрүүдээр оруулах, сурталчлах чиглэлээр иргэд болон өрхийн дунд “Хайр түгээе” уралдааны удирдамж гарган ажилласан бөгөөд “Шинэжинст сумын байгаль” группээр модоо тарьж байгаа байдлаа сурталчлах зорилго агуулсан уралдаан явуулсан. Сургуулийн дунд бүлгүүдийн 28 сурагчдыг “Мод тарих арга” сургалтанд 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хамруулснаар өөрсдөө хөрсөө бэлтгэх, мод тарих, арчлах аргуудыг биечлэн хийж, хайрлаж хамгаалах арга ухаанд суралцав. Мэдээллийн цагаар Байгаль орчны чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажил болон хууль тогтоомж, мод тарих чиглэлээр байгууллагуудын албан хаагчид, ажилчдад 3 удаагийн мэдээлэл, сурталчилгааг хийж ажиллан нийт 228 иргэн хамрагдсан. Хавсралт : 1 файл | 100% |
| 77 | | 5.1.4. “Хоггүй Шинэжинст” аяныг зохион байгуулж хог хаягдлын | 2021 - 2024 | 1сая төгрөг | | Сумын хэмжээнд хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж, түүний дагуу Сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн “Хог хаягдлыг цэвэрлэх ажлыг эрчимжүүлэх тухай”, Эхэнхавцгай багийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Хог | 100% |

| | | | | | | |
|----|--|---|-------------|---------|--|------|
| | | менеджментийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангана. | | | <p>хаягдлын их цэвэрлэгээг зохион байгуулах тухай” захирамжуудын хүрээнд нийтийн их цэвэрлэгээ 5 удаа зохион байгуулагдаж нийт 250 иргэн хамрагдан 25 тн хог хаягдал хогийн цэгт хүргэж ажилласан байна. Энэ онд хогийн цэгийг дарж булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажил хийгдсэн бөгөөд “Эрдэнэ Монгол” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд санхүүжилтийг шийдвэрлэн “Талын нөмөр” ХХК гэрээгээр гүйцэтгэсэн.</p> <p>Хавсралт : 1 файл</p> | |
| 78 | | 5.1.5. Зэрлэг амьтдыг хамгаалах, өвс тэжээлийн хомсдлоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр зэрлэг амьтны байршил бүхий газруудад био техникийн арга хэмжээ авна. | 2021 - 2024 | 5400000 | <p>Тус сумын нутагт ангийн бүс нутгаар “Агьт” бүс нутаг тодорхойлогдсон бөгөөд зэрлэг ан амьтанд зориулсан биотехникийн арга хэмжээг уг ангийн бүс нутагт голчлон тавьж хэрэгжүүлж байна. 2023 оны 1дүгээр сар, 3 дугаар сар, 4 дүгээр сар, 5 дугаар сар, 6 дугаар саруудад 8 цэгт 5 удаагийн давтамжаар өвс тавих, хуцир тавих ажлыг Засаг даргын Тамгын газрын хамт олон, Байгаль орчны ажилтнууд хамтран нийт 33 иргэн оролцож, тавьж ажилласан. Биотехникийн арга хэмжээнд нийт 6200000 төгрөг зарцуулсан байна. “Цоохондойт уулынхан” ТББ Дулаан, Хиагтын ууланд 40 боодол өвс хүргэж ажилласан. ГИДЦГ-ын бүс нутагт мазаалайг ичээнээс гарах үед пункерт тэжээл тавих ажилд Байгаль хамгаалагчид хамтран оролцсон. Мөн 100 боодол өвс тавих 2 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн байгаа учир цаг хүндрэх үед авч хэрэгжүүлэх боломжтой байна.</p> <p>Хавсралт : 1 файл</p> | 100% |
| 79 | | 5.1.6. 6 Булгийн эхийг хамгаалах ундрагыг сэргээх ажлыг иргэд, малчид, нөхөрлөлийн | 2021 - 2024 | 13 сая | <p>Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслийн 13 сая төгрөгийн санхүүжилтээр “Хаяа” булгийн эхийг хамгаалах ажлыг “Дошлуур чулуут” ТББ хариуцан гүйцэтгэж орон нутагт хүлээлгэн өгсөн бөгөөд малчин идэвхтэн байгаль хамгаалагч Х.Одонтунгалагт хариуцууллаа. НҮБ-ын санхүүжилтээр нэг худаг</p> | 100% |

| | | | | | | |
|----|---|-------------|-------|--|--|------|
| | оролцоотойгоор хийж хэрэгжүүлнэ. | | | | тохижуулах ажлыг хариуцагч аж ахуйн нэгж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Энэ худгаас сумын төвийн иргэд ногоон байгууламж болон ахуйн хэрэглээнд үнэ төлбөргүйгээр хэрэглээ хийж байна. Хавсралт : 1 файл | |
| 80 | 5.1.7. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хяналтыг сайжруулна. | 2021 - 2024 | 500,0 | | Байгаль орчин аялал жуулчлалын яамны салбарын улсын ахлах байцаагчийн удирдамжийн дагуу хяналт шалгалт хийгдэх болсоноор салбарын ахлах байцаагчийн удиордамж 4 дүгээр сард батлагдсанаар хяналт шалгалт хийгдэх эрхзүй бүрдсэн. Тус сумын нутаг дэвсгэрт байгаль орчны холбоотой хяналт шалгалтуудыг тухай бүр хийж ажиллалаа. Иргэдийн гомдол мэдээллээр төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг “Баянхөх толгой” ХХК, “Эрдэнэмонгол” ХХК, “Сэкер ресорсус Монголиа” ХХК, “Эрдэнэс Алт” ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудын тусгай зөвшөөрлийн талбайд хийж, 8 албан шаардлага тус бүрт хүргүүлж, дутагдлыг арилгуулсан, 3 зөрчилд шийтгэлийн арга хэмжээ авч ажилласан байна. Нийт 15 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч төлбөрийг бүрэн барагдуулсан байна. | 100% |
| 81 | 5.1.8. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулна. | 2021 - 2024 | | | Сумын төвийн ундны усны хангамжийн эх үүсвэрийг сайжруулах зорилгоор “Эрдэнэ Монгол” ХХК иргэдээс гаргасан санал хүсэлтийн дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд өөрийн 100 хувийн санхүүжилтээр усны эх үүсвэрийн байгууламжийг бий болгосон бөгөөд эрүүл ахуйн бүсийг тэмдэгжүүлж, хашаа хайсжуулсан. Ундны усны шинжилгээг төрийн байгууллагын зүгээс хими болон нянгийн шинжилгээнд улирал тутамд буюу нийт 4 удаа /5 худаг/ , Эрдэнэ Монгол ХХК нэг худгаас 3 удаа шинжилгээнд хамруулж ажилласан. Сумын төвийн “Дээд хүрэнгийн худаг”-аас ундны усны хэрэглээг хийж хангаж ажиллаж байна. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн | 90% |

| | | | | | | |
|--|--|---|-------------|------|--|-----|
| | | | | | хэрэгжилтийг хангуулж ажиллаж байна. | |
| 82 | | 5.1.9. Орон нутгийн аялал жуулчлал, бизнесийг дэмжих технологийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | 1сая | Дэлхийд 2 дугаарт, Монголдоо хамгийн бүдүүн Хаан тоорой Баянхонгор амйгийн Шинэжинст суманд байдаг бөгөөд түүнийг үзэхээр жуулчид олноор очиж үзэж сонирхдог учир тэнд тайлбарыг чулуун дээр байрлуулж, аялагчдад орон нутгаа таниулах боломжийг харуулах зорилготой мэдээллийн чулуун самбар байрлуулж өгсөн. Санхүүжилт 1 сая төгрөгөнд хэрэгжсэн байна. Мөн Эхийн гол хүртэлх тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын бүсүүдэд 10 тэмдэг тэмдэглэгээг Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслийн хүрээнд хэрэгжүүлж ажиллалалаа. Хавсралт : 5 зураг | 90% |
| 83 | | 5.1.10. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг эмх цэгцтэй, бодит байдлаар хийж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд “Жишиг гудамж” хороолол арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 2021 - 2024 | | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан эмх цэгцтэй төлөвлөж байна. Урд ондуудад эмх замбараагүй олгогдсон гудамж хашааг цэгцлэх, жишиг гудамж болгох талаар 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгахаар төлөвлөж байна. | 30% |
| 6. Зургаа: Амар тайван, аюулгүй нийгмийн бодлого | | | | | | |
| 84 | 6.1. Иргэдийн амар тайван байдлыг хангах | 6.1.1. Сумын хэмжээнд гарч буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, | 2021 - 2024 | 1сая | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлуудыг санаачлан хийж хэрэгжүүллээ. Хийгдсэн ажлуудаас айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын байршлын булан тохойд 8 хаалт, 10 тэмдэг тэмдэглээг замын аюулгүй | 90% |

| | | | | | | |
|----|--|---|-------------|--|---|------|
| | | нөхцлийг тогтоон, урьдчилан сэргийлж хяналтыг сайжруулна. | | | байдлыг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн. мөн сургалт сурталчилгааны чиглэлээр багуудын иргэдийн нийтийн 2 удаагийн хурлууд, 2 удаагийн иргэдийн цуглаан зэрэг нийтийг хамарсан газарт тухай бүр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээллийг 1200 гаруй иргэдэд хүргэж ажиллана. Хавсралт : 1 файл | |
| 85 | | 6.1.2. Малчдын бүлгэмийг шинэчлэн байгуулан, үйл ажиллагааг эрчимжүүлж, хамтран ажиллана. | 2021 - 2024 | Зараа баг бүлгүүдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх тэмцээний шагналын санг "Хөдөлгөөн ба эрүүл мэнд"- 2023 уралдаанд амжилттай оролцож шагнуулсан 1,000,000 төгрөгөөр уралдаан тэмцээнээ зохион байгуулж ивээн тэтгэв. Уртын гол баг бүлэг хоорондын тэмцээнийг "Задгай хээр" малчидын бүлэг, Эрдэнэшанд | Зараа багийн малчид, ард иргэд хөдөлмөрчид 4 бүлэгт хуваагдан бэлчээр сэлгэх өвөлжөө бууцны бэлчээр чөлөөлөлт худаг ус, хашаа хороо сэргээн засварлах зэрэг ажлаар хамтран ажилладаг. 2023 оны бүлгүүдийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 11 сарын 07-08 өдрүүдэд зохион байгуулав. Эрдэнэшанд багийн малчидын 7 бүлэгт хуваагдаж бэлчээр ашиглалт зохион байгуулж ажиллаж байна. Бүлгүүдийн оролцоог идэвхижүүлэх 2023 оны хийсэн ажлыг дүгнэж 2023 оны 11 сарын 27 өдөр зохион байгуулав. Уртын гол багийн малчид 8 бүлэгт хуваагдаж малчидын идэвхи оролцоог нэмэгдүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж байна. 2023 оны шилдэг зохион байгуулалттай ажилсаг, спортлог бүлэг шалгаруулах уралдаан тэмцээнийг 2023 оны 12 сарын 08-09 өдрүүдэд зохион байгуулж ажиллав. Эхэнхавцгай 4-р баг нь гудамж хороололын байршилаар хэсэгт хуваагдан эко гудамж. эрүүл чийрэг ирээдүй уралдааныг зарлан хоггүй цэвэр амьдрах, нохойгоо тогтмол уях, хашаагаа тэгшлэх ажлуудыг үнэлэн дүгнэж шилдэг хороолол шалгаруулан 2023 оны 12 сарын 18 өдөр шагнал гардуулах ажлыг зохион байгуулав. | 100% |

| | | | | | | |
|----|--|----------------|--|---|---------------------|------|
| | | | | багийн бүлэг хоорондын тэмцээнийг Багийн Иргэдийн хурлын төлөөлөгчид ивээн тэтгэж зохион байгуулав. | | |
| 86 | 6.1.3. Малчдын бүлгэмийг шинэчлэн байгуулан, үйл ажиллагааг эрчимжүүлж, хамтран ажиллана. | 2021 - 2024 | Зараа баг бүлгүүдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх тэмцээний шагналын санг "Хөдөлгөөн ба эрүүл мэнд"- 2023 уралдаанд амжилттай оролцож шагнуулсан 1,000,000 төгрөгөөр уралдаан тэмцээнээ зохион байгуулж ивээн тэтгэв. Уртын гол баг бүлэг хоорондын тэмцээнийг "Задгай хээр" малчидын | Зараа багийн малчид, ард иргэд хөдөлмөрчид 4 бүлэгт хуваагдан бэлчээр сэлгэх өвөлжөө бууцны бэлчээр чөлөөлөлт худаг ус, хашаа хороо сэргээн засварлах зэрэг ажлаар хамтран ажилладаг. 2023 оны бүлгүүдийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 11 сарын 07-08 өдрүүдэд зохион байгуулав. Эрдэнэшанд багийн малчидын 7 бүлэгт хуваагдаж бэлчээр ашиглалт зохион байгуулж ажиллаж байна. Бүлгүүдийн оролцоог идэвхижүүлэх 2023 оны хийсэн ажлыг дүгнэж 2023 оны 11 сарын 27 өдөр зохион байгуулав. Уртын гол багийн малчид 8 бүлэгт хуваагдаж малчидын идэвхи оролцоог нэмэгдүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж байна. 2023 оны шилдэг зохион байгуулалттай ажилсаг, спортлог бүлэг шалгаруулах уралдаан тэмцээнийг 2023 оны 12 сарын 08-09 өдрүүдэд зохион байгуулж ажиллав. Эхэнхавцгай 4-р баг нь гудамж хороололын байршилаар хэсэгт хуваагдан эко гудамж. эрүүл чийрэг ирээдүй уралдааныг зарлан хоггүй цэвэр амьдрах, нохойгоо тогтмол уях, хашаагаа тэгшлэх ажлуудыг үнэлэн дүгнэж шилдэг хороолол шалгаруулан 2023 оны 12 сарын 18 өдөр шагнал гардуулах ажлыг зохион байгуулав. | Хавсралт : 13 зураг | 100% |

| | | | | | | |
|----|--|--|-------------|--|---|-----|
| | | | | бүлэг, Эрдэнэшанд багийн бүлэг хоорондын тэмцээнийг Багийн Иргэдийн хурлын төлөөлөгчид ивээн тэтгэж зохион байгуулав. | | |
| 87 | | 6.1.4. Сумын хэмжээний архины хамааралтай иргэдийг соён гэгээрүүлэх үүднээс “Жаргалтай амьдрал төв”-тэй хамтран ажиллана. | 2021 - 2024 | | Согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдаалдаг, ААН үүдэд улиралд 1 удаа хяналт шалгалтыг хийлээ. Шөнө архи зарсан 1 дэлгүүрт сануулах арга хэмжээ авч ажиллаж байна. Сумын ГХУСАЗСЗ-аас “Архигүй ажиллаж амьдарцгаая” уриалгыг гаргаж баг, байгууллага, иргэдэд сурталчилж байна. Олон нийтийн газар архидан согтууруулах зөрчлөөс сэргийлж 2 самбарыг Соёлын төв, сургуулийн спорт заланд байршууллаа. Хавсралт : 1 файл | 90% |
| 88 | 6.1. Иргэдийн амар тайван байдлыг хангах | 6.1.5. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн тоог бууруулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. | 2021 - 2024 | | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн ажлыг сургалт сурталчилгааг голчлон хийлээ. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас мэргэжилтнүүд 2 удаа ирж сургалт хийгдсэн. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас баривчлагдсан хүмүүсийн гэр бүлийн гишүүдэд 2 удаа, төрийн албан хаагч нарт нийт 140 гаруй албан хаагч нарт сургалт 1 удаа зохион байгуулсан байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 2 хэргийг илрүүлж, холбогдох арга хэмжээг авч ажилласан. Хавсралт : 1 файл | 90% |

